



**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/25


Улаанбаатар хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

Архивын тухай хуулийн 15 дугаар зүйл, Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан "Байгууллагын архивын ажлын үндсэн заавар"-ын 10.1.1, 10.1.2 дахь заалт, "Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар"-ын 1.2, 1.5, 1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн архивын газраас өгсөн зөвлөмжийн дагуу "Байгууллагын архивын дүрэм"-ийг шинэчлэн, хавсралтаар баталсугай.
2. Байгууллагын архивын шинэчилсэн дүрмийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг газрын нийт ажилтнуудад, мэргэжлийн заавар зөвлөгөө өгч ажиллахыг Архивын ажилтан /Д.Одгэрэл/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Баримт бичиг нягтлан шалгах комиссын дарга /С.Майнбаяр/-д даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2015 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн А/76 тоот тушаалын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЭНХСАЙХАН